



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/25

Бодь

Малын халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Монгол Улсын Засгийн газрын Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/177 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулахыг “Дундрашгүй баялаг” хариуцлагтай хувьцаат компаний захирал С.Эрдэнэ, “Эрдэнэт таван богд” хариуцлагтай хувьцаат компаний захирал Л.Эрдэнэбилэг нарт үүрэг болгосугай.


2. Дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн дотор тухайн малчны хотноос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх, зах зээлд борлуулах үйл ажиллагааг малчид, иргэд, аж ахуй нэгжүүдэд хориглосугай.

3. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажлыг цаг хугацаа чанар стандартын дагуу хийж гүйцэтгээгүй, мал сүргийг бүрэн хамруулаагүй тохиолдолд мал амьтаны эрүүл мэндийн тухай хууль, зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг малчид, мал бүхий иргэдэд, суртачилхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч /А.Лхагвабаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ



642201029